



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдөр  
Тендер шалгаруулалтын нэр: Монголбанкны төв байранд ялтсан бойлер тавих ажил гүйцэтгэх  
Тендер шалгаруулалтын дугаар: ҮаВ-2016/02

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчоос төв байранд ялтсан бойлер тавих ажил гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн бичиг баримтыг бичгээр хвсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000.00 (тавин мянган) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд (дансны нэр: тендерийн хороо) тушаана. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хвчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.  
Үүнд:  
Борлуулалтын хэмжээ: 80,000,000.00 төгрөг,  
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 80,000,000.00 төгрөг,  
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жил: 2015, 2014 он.

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 2 (хоёр) хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.

Тендерийг 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хвсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

## МОНГОЛБАНК

Бага тойруу -3, 15160, Улаанбаатар хот,  
Монголбанкны “А” байрны 1 давхар, 2 тоот өрөө,  
Утас: (976-11) 310633, 319295 Факс: (976-11) 311471